



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/190

Булган сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсаа төлөөлөн өрсөлдөх ур чадвартай тамирчдыг бэлтгэх, боксын спортыг хөдөө орон нутагт хөгжүүлэх, сурталчлах, бие бялдрын өв тэгш хүмүүжил олгох зорилгоор "Бугат цом" боксын холимог насны аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсугай.

2. "Бугат цом" боксын тэмцээнд дэмжлэг үзүүлэн 6,200,000 (зургаан сая хоёр зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ